



“ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН”
ҮЙЛДВЭРИЙН САЙД Ц.ИДЭРБАТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.14 № 57

“ Малын шүлхийн вакцины талаар ”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн Танд энэхүү асуултыг тавьж байна.

1.Улсын хэмжээнд одоогийн байдлаар хэдэн аймаг, суманд шүлхийн голомт бүртгэгдсэн, нийт хэдэн толгой мал өвчилснөөс хэдийг устгалд оруулсан нэгдсэн тоон мэдээлэл;

2.Шүлхийн вакцинжуулалтад хамруулахаар төлөвлөсөн болон одоогийн байдлаар хамрагдсан малын тоон мэдээлэл;

3.Шүлхийн вакцин хийлгэсэн малын дархлааны тогтоц, вакцины үр дүнг лабораторийн шинжилгээгээр хэрхэн баталгаажуулж байгаа талаар;

4.2026 онд шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцин худалдан авах, лабораторийн шинжилгээ хийх, хорио цээр тогтоох, устгал хийх, нөхөн олговор олгохоор төсөвлөсөн төсвийн хэмжээ, зарцуулалтын талаарх мэдээлэл;

5.Цаашид улсын хэмжээнд O, SAT-1 болон бусад хэвшлийн шүлхийн вакцины нөөц бүрдүүлэх талаар төлөвлөж байгаа эсэх;

6.Импортоор оруулахыг зөвшөөрснөөс бусад улсаас шүлхийн вакцин оруулж байгаа эсэх талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Г.ХОСБАЯР

2026000167